



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх
төрийн зохицуулалтын үр нөлөөт байдал
ҮАГ – ГАГ/2015/08-ГА-ХөААГ

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 20-р тогтоол,
аймгийн Аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний
төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Хууль бус загасчлалын зөрчил их байна.



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2015 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/36

Мөрөн

Аудитын тайлан баталгаажуулах тухай

МУ-ын Ерөнхий аудиторов 2014 оны 121, Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2015 оны 04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, аймгийн Онцгой байдлын газар, Хилийн цэргийн 0257-р анги, Ханх дахь гаалийн хороонд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллан үр дүнг 2016 оны 04 дүгээр сарын 01-ний дотор багтаан аймгийн Аудитын газарт ирүүлэхийг аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга Р.Жаргалсайхан, аймгийн Онцгой байдлын газрын дарга Г.Нэргүй, Хилийн цэргийн 0257-р ангийн захирагч Б.Батбаяр, Ханх дахь гаалийн хорооны дарга Ч.Саранхүү нарт зөвлөсүгэй.
4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын менежер /Г.Эрдэнэчимэг/, ахлах аудитор /Г.Нямлхагва/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /Г.ОЮУНГЭРЭЛ



АГУУЛГА

Хуудасны
дугаар

Тайланг бэлтгэсэн:
ХөААГ-ын
Гүйцэтгэлийн
аудитын баг

Тэргүүлэх аудитор

Г.Оюунгэрэл

Утас: 96665871

Аудитын менежер

Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320

Багийн ахлагч :

Ахлах аудитор

Г.Нямлхагва

Утас: 96380550

Багийн гишүүн:

Шинжээч

Б.Сандуйжав

2015 оны 10 дугаар сар

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утсаар харилцана уу.

Цахим хуудас:

www.audit.mn

ХАЯГ:

Мөрөн сум Аймгийн ЗДТГ-ын “А” корпус 3 давхар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй

4

5

Бүлэг 1. Ой, хээрийн түймрээс сэргийлэх, хамгаалах талаар үр дүнтэй ажиллаж байна.

8

1.1 Ой, хээрийн түймрээс сэргийлэх, хамгаалах талаар үр дүнтэй ажиллаж байна.

8

1.2 Хил орчмын гол мөрний эхийг улсын тусгай хамгаалалтад хамруулсан байна.

9

1.3 Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа хууль бус гэрээ байгуулсан байна.

11

Бүлэг 2. Хил орчмын байгаль орчныг хамгаалахад тусгайлан хөрөнгө батлаагүй байна.

13

2.1 Хил орчмын байгаль орчныг хамгаалахад тусгайлан хөрөнгө батлаагүй байна.

13

2.2 Зарим хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй байна.

14

2.3 Байгаль орчинд учирсан хохирлын экологи, эдийн засгийн үндэслэлийг бодитой тооцохгүй байна.

17

Дүгнэлт

18

Зөвлөмж

19

Холбогдох байгууллагын санал

20

Зөрчлийн жагсаалт

21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ХөААГ	Хөвсгөл аймгийн аудитын газар
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОБГ	Онцгой байдлын газар
УТХГХЗ	Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа
ОХУ	Оросын Холбооны Улс
ДЦГ	Дархан цаазат газар
БЦГ	Байгалийн цогцолбор газар
БДГ	Байгалийн дурсгалт газар
УЦУОША	Ус цаг уур, орчны шинжилгээний газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БОХУ	Байгаль орчны хяналтын улсын

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 20-р тогтоол, аймгийн Аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлийн аудит хийв.

Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтанд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Төрийн захиргааны байгууллагууд хил орчмын байгаль орчныг хамгаалах талаар үр нөлөөтэй ажиллаж буй эсэх.
- Хил орчмын байгаль орчныг хамгаалахад зориулсан улс, орон нутгийн төсвийн хөрөнгө үр нөлөөтэй зарцуулагдсан эсэх.

Аудитад аймгийн ЗДТГ-ын ХБХ, БОАЖГ, МХГ, ОБГ, Ханх суман дахь Гаалийн хороо, Хилийн цэргийн 0257-р анги, түүний харьяа 1, 3, 8, 9-р застав, Цэцэрлэг, Цагаан-Уул, Ханх, Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдын ЗДТГ, Хөвсгөлийн УТХГХЗ, Улаан тайгын УТХГХЗ хамрагдлаа.

Аудитын төлөвлөлт болон урьдчилсан судалгаа, түүнд хийгдсэн дүн шинжилгээ, харилцагч байгууллагуудын холбогдох албан тушаалтантай хийсэн ярилцлага, бусад баримт, тулган баталгаажуулалтыг үндэслэн ерөнхий эрсдэлийг **“ДУНД”** гэж үзлээ.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашигласнаас гадна холбогдох газруудад аудитын горимын дагуу асуудлыг шинжлэн судлах, асуулга, ярилцлага хийж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу дэмжлэг болох нотлох зүйлс, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад хамрагдсан хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах хууль, эрх зүйн акт, баримт бичгийг аудитын шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Амьтны тухай хууль
- Ойн тухай хууль
- Усны тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- Монгол улсын хилийн тухай хууль
- Монгол улсын 2013 оны төсвийн тухай хууль
- Монгол улсын 2014 оны төсвийн тухай хууль
- Монгол улсын 2015 оны төсвийн тухай хууль
- Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоол
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 394 тоот тушаал
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, гүйцэтгэлийн шалгалтын журам, Тэргүүлэх аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөөг удирдлага болгон ажиллалаа.

Гүйцэтгэлийн аудитыг Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл удирдаж, аудитын менежер Г.Эрдэнэчимэг арга зүйгээр ханган, явцын хяналт тавьж, шинжээч Б.Сандуйжав 2015 оны 09 дүгээр сарын 02-оос 2015 оны 10 дугаар сарын 30-ны хооронд гүйцэтгэлээ. Аудитын талбарын үе шатанд ҮАГ-ын ГАГ-ын аудитын менежер Д.Баттулга хамтран ажилласан болно.

Үндсэн мэдээлэл

Хөвсгөл аймаг нь ОХУ-тай 1027,4 км газар нутгаар хиллэдгээс Тува улстай 506,8км, Буриад улстай 520,6 км-ээр хиллэдэг. Үүнээс ОХУ-ын Тува улстай хилийн 289-350 дугаар тэмдэгт /Монгол Шарын даваа/ хүртэл 506,9 км, Буриад улстай 350-478 дугаар тэмдэгт бүхий /Их илэнхийн гол/ хүртэл 520,6 км газраас тус тус хиллэж байна.

ОХУ-ын Буриад улстай хиллэдэг хэсэгт Буриад улсаас Тункинск, Окинск, Закаменск районууд багтдаг бол Хөвсгөл аймгийн Цагааннуур, Улаан-Уул, Ханх, Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдууд хамрагддаг. ОХУ-ын Тува улстай Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан-Уул, Баянзүрх сумдууд хиллэж байна.


Хил орчмын сумдуудад нийт 10 застав ажилладаг ба үүнээс 5 нь хээрийн, 5 нь сумын төвд байрлаж байна.

Хөвсгөл аймагт Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул сумын нутаг дэвсгэрийг хамарсан Тэнгис-Шишгэдийн голын 875.771 га талбайтай БЦГ, Улаан-Уул, Баянзүрх сумын нутгийн зарим хэсгийг хамарсан 434900 га талбайтай ДЦГ, Улаан-Уул, Рэнчинлхүмбэ сумын нутаг дэвсгэрийг хамарсан 188634 га талбай бүхий ДЦГ, нийт 1203903 га талбай бүхий Хөвсгөлийн БЦГ, Даян дээрхийн БДГ-ууд байна.

Эдгээр газруудыг Улаан-Уул суманд байрлах Улаан тайгын УТХГ-ын хамгаалалтын захиргаа, Хатгал тосгонд байрлах Хөвсгөлийн УТХГ-ын хамгаалалтын захиргаанууд хариуцан үйл ажиллагаа явуулж байна. Улаан тайгын УТХГХЗ нь 4 сумын нутаг дэвсгэрт 2ДЦГ, 1БЦГ-ыг, Хөвсгөлийн УТХГХЗ нь 5 сум, 1 тосгоны нутаг дэвсгэрт 1 БЦГ, 1 БДГ-ыг тус тус хариуцан ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн 50-р өргөрөгөөс хойшхи газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан байна.

БОНХАЖЯ-аас гаргасан судалгаагаар Хөвсгөл аймагт ОХУ-аас 5 гол урсан орж ирдэг, ОХУ-руу 2 гол урсан гардаг байна. Эдгээр голуудаас Цагааннуур сумын Шишхэд голд аймгийн УЦУОША-ны харуулын цэг байдаг бөгөөд усны чанарт шинжилгээ хийх боломжтой байна.



1.1 Ой, хээрийн түймрээс сэргийлэх, хамгаалах талаар үр дүнтэй ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2013 оны А/71 дүгээр захирамжаар “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг зохицуулах зөвлөл”-ийг байгуулж, мөн оны А/75 дугаар захирамжаар “2013-2016 онд ой, хээрийн гал түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах төлөвлөгөө”-г баталсан байна. Энэхүү төлөвлөгөөний дагуу зөвлөл нь ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг жил бүр зохион байгуулж байна. Төлөвлөгөөний дагуу зохион байгуулж буй ажлуудаас товч дурьдвал:

- Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, эргүүл ажиллуулах, шаардлагатай багаж, зэвсэглэмжийн нөөц бүрдүүлэх зорилгоор сум бүрт 3 сая төгрөг хуваарилж, гал түймэртэй тэмцэх багаж, зэвсэглэмжийн нөөцтэй болгосон байна.
- Аймгийн БОАЖГ, ОБГ хамтран сумдын удирдлагуудад багаж, зэвсэглэмжийг хэрхэн ашиглах талаар онол, дадлагын сургалт хийн, гарын авлага, зөвлөмжийг өгсөн байна.
- Түймрийн эрсдэлтэй улиралд иргэд, ААНБ-ыг урьдчилан сэргийлэх сургалтанд хамруулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга сурталчилгаа хийх, сум дундын ойн ангиар дамжуулан сумдад мэдээлэл хүргүүлэх зэрэг ажил хийсэн байна.
- Хил дамнасан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар Хилийн цэргийн 0257-р анги ОХУ-ын Буриад улсын төлөөлөгч, Хиагтын хилийн заставын даргатай “Хил дээр түймэр гаргуулахгүй байх, гарсан тохиолдолд хүн, техник хэрэгслийг солилцож ажиллах, 2 талын хил рүү 50 км-ийн гүнд байнга эргүүл хяналт хийх” талаар гэрээ байгуулан эхний ээлжинд ажиллах бүлгийг бататгасан байна.
- Аймгийн МХГ, Цагдаагийн газар, ОБГ, БОАЖГ-ын хамтарсан ажлын хэсэг гарч эргүүл, шалгалт хийн гарсан зөрчлийг арилгуулсан, нийт сумдад 143 урамшуулалт морин эргүүл ажиллуулж байгаа зэрэг ажлуудыг хийж байна.

Мөн дараах байгууллагууд хамтран ажиллах төлөвлөгөө гарган ой, хээрийн түймэртэй тэмцэх чиглэлээр арга хэмжээнүүд төлөвлөн ажиллаж байна. Дурьдвал:

- 2014 онд аймгийн Засаг дарга ОХУ-ын Буриад улсын Ахын аймгийн даргатай хэлэлцсэн асуудалд хил дамнасан түймэр гарсан тохиолдолд авах арга хэмжээний талаар тусгасан байна.
- Мөн аймгийн ОБГ Хилийн цэргийн 0257-р ангитай хамтран ажиллах төлөвлөгөө гарган, уг төлөвлөгөөнд ой, хээрийн түймэр гарсан үед шаардлагатай арга хэмжээ авах талаар тусган ажиллаж байна.

- Хилийн сумдууд “Хил хамгаалах туслах хүчний зөвлөл” байгуулан жил бүр төлөвлөгөө батлаж ой, хээрийн түймэртэй тэмцэх чиглэлээр хилийн заставуудтай хамтран ажиллаж байна.

Хил орчимд гарсан түймрийн мэдээг сүүлийн 6 жилийн байдлаар харуулбал:

Хилийн цэргийн 0257-р ангиас ирүүлсэн түймрийн мэдээ

Хүснэгт 1:

	Огноо					
	2010	2011	2012	2013	2014	2015
Түймрийн тоо	5	3	12	2	1	10

Хүснэгтэд үзүүлсэн сүүлийн 3 жилийн түймрийн мэдээг аймгийн ОБГ, БОАЖГ-аас ирүүлсэн мэдээтэй тулган үзэхэд зөрүүтэй байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2:

Огноо	Түймрийн мэдээ		
	Хилийн цэргийн 0257-р анги	ОБГ	БОАЖГ
2013	2	0	0
2014	1	2	1
2015	10	8	9
Нийт	12	10	10

Хүснэгтээс харахад: Эдгээр байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.

1.2 Хил орчмын гол мөрний эхийг улсын тусгай хамгаалалтад хамруулсан байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2011 оны 124 дүгээр тогтоолоор “Ус”¹ аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт баталсан байна. Уг хөтөлбөрт хил орчмын гол мөрний талаар дараах заалтууд орсон байна. Үүнд:

- Хөтөлбөрийн 3.2.6-д “ОХУ-ын Тува улс руу урсдаг Шишхэд гол, Тува улсын хилийг даган урсдаг Дэлгэрмөрөн голын асуудлаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах”
- Хөтөлбөрийн 3.2.7-д “Хилийн усны хяналт шинжилгээ явуулах талаар Цагааннуур сумын Шишхэд гол дээр усны харуул байгуулж ажиллуулах”
- Хөтөлбөрийн 3.2.8-д “Хилийн усны хяналт шинжилгээг тогтоосон үзүүлэлтээр тогтмол горимын дагуу явуулж холбогдох мэдээллийг төвд шуурхай дамжуулах, мэдээлэл солилцох боломжоор хангах”
- Хөтөлбөрийн 3.3.2-д “Эг, Шишхэдийн гол дээр урсацын тохируулга хийх талаар судалгаа шинжилгээний ажил хийх” гэсэн заалтууд орсон байна.

Эдгээр ажлуудаас Цагааннуур сумын Шишхэд гол дээр усны харуул байгуулах ажил 2013 онд хийгдэн, усны өнгөрөлт, бохирдол зэрэг горимын ажиглалтуудыг аргачлалын дагуу гүйцэтгэж байна. Бусад ажлуудын тухайд хэрэгжих хугацаа нь болоогүй байна.

¹ Уг хөтөлбөр нь 2011-2021 он хүртэл хугацаанд хэрэгжинэ.

Хөвсгөл аймгийн нутгаас эх аван урсаж байгаа Дэлгэрмөрөн, Үүр, Эг, Бүгс, Тэс голууд нь бусад аймгийн нутгаар дамжин хил гардаг бөгөөд аймгийн нутгаас эх аван хил гарч байгаа голуудын эхийг улсын тусгай хамгаалалтад авч хамгаалах ажлууд хийгдэж одоогийн байдлаар Эг, Үүр, Дэлгэрмөрөн, Шишхэд голуудын эхийг тусгай хамгаалалтад хамруулсан байна. Тэсийн голын эхийг тусгай хамгаалалтад хамруулах үндэслэл санал боловсрогдон БОНХАЖЯ-нд өргөн баригдсан байна.

БОНХС аймгийн Засаг даргын 2014 оны ногоон хөгжлийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх гэрээнд Тэсийн голын эх орчмыг ойжуулахаар заасны дагуу 50 га-д навчит мод, 100 га-д шинэс модны 2-3 настай тарьцаар ойжуулалт хийсэн байна.

Хил даван урсаж буй Шишхэд гол болон хил орчмын гол мөрөн, нууранд ажиллаж байгаа усны харуулын авсан дээжийн шинжилгээний дүнг аймгийн МХГ-аас авахад дараах байдалтай байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3:

№	Нуур, гол мөрний нэр	Шинжилгээний дүн
1	Хөвсгөл	2013, 2014, 2015.09 сарын байдлаар авсан дээжнүүдэд аммоны азот /NH ₄ / 0.06-0.37 мг/л хэмжээтэй агуулагдаж байгаа нь гадаргын усны цэврийн зэрэглэлийн ангиллын нормын 3-р зэрэг буюу бага бохирдолттой усны ангилалд хамрагдаж байна. Аммоны азотоос бусад үзүүлэлтээр маш цэвэр, цэвэр ус болох нь тогтоогдсон байна.
2	Шишхэд	2013, 2014, 2015.09 сарын байдлаар авсан дээжнүүдэд аммоны азот /NH ₄ / 0.1-0.59 мг/л хэмжээтэй агуулагдаж байгаа нь гадаргын усны цэврийн зэрэглэлийн ангиллын нормын 3-р зэрэг буюу бага бохирдолттой усны ангилалд хамрагдаж байна. Аммоны азотоос бусад үзүүлэлтээр маш цэвэр, цэвэр ус болох нь тогтоогдсон байна.
3	Дэлгэрмөрөн	2013, 2014, 2015.09 сарын байдлаар авсан дээжнүүдэд аммоны азот /NH ₄ / 0.1-0.63 мг/л хэмжээтэй агуулагдаж байгаа нь гадаргын усны цэврийн зэрэглэлийн ангиллын нормын 3-р зэрэг буюу бага бохирдолттой усны ангилалд хамрагдаж байна. Аммоны азотоос бусад үзүүлэлтээр маш цэвэр, цэвэр ус болох нь тогтоогдсон байна.
4	Үүр	2013, 2014, 2015.09 сарын байдлаар авсан дээжнүүдэд аммоны азот /NH ₄ / 0.1-0.73 мг/л хэмжээтэй агуулагдаж байгаа нь гадаргын усны цэврийн зэрэглэлийн ангиллын нормын 3-р зэрэг буюу бага бохирдолттой усны ангилалд хамрагдаж байна. Аммоны азотоос бусад үзүүлэлтээр маш цэвэр, цэвэр ус болох нь тогтоогдсон байна.
5	Уйлган	2013, 2014, 2015.09 сарын байдлаар авсан дээжнүүдэд аммоны азот /NH ₄ / 0.14-0.5 мг/л хэмжээтэй агуулагдаж байгаа нь гадаргын усны цэврийн зэрэглэлийн ангиллын нормын 3-р зэрэг буюу бага бохирдолттой усны ангилалд хамрагдаж байна. Аммоны азотоос бусад үзүүлэлтээр маш цэвэр, цэвэр ус болох нь тогтоогдсон байна.
6	Хороо	2013, 2014, 2015.09 сарын байдлаар авсан дээжнүүдэд аммоны азот /NH ₄ / 0.1-0.58 мг/л хэмжээтэй агуулагдаж байгаа нь гадаргын усны цэврийн зэрэглэлийн ангиллын нормын 3-р зэрэг буюу бага бохирдолттой усны ангилалд хамрагдаж байна. Аммоны азотоос бусад үзүүлэлтээр маш цэвэр, цэвэр ус болох нь тогтоогдсон байна.

1.3 Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа хууль бус гэрээ байгуулсан байна.

Тус аймгийн Улаан-Уул суманд байрлах Улаан тайгын УТХГХЗ, Хатгал тосгонд байрлах Хөвсгөлийн УТХГХЗ-нууд үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр газрууд нь үйл ажиллагаа явуулж буй сумдуудын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний дагуу сумдын Байгаль орчны тогтвортой хөгжлийн бодлогын тасагтай хамтран шалгалт хийн гарсан зөрчилд холбогдох арга хэмжээ авч ажилласан байна.

Хөвсгөлийн УТХГХЗ нь ОХУ-ын Буриад улсын Тункен аймгийн Үндэсний паркттай хамтран ажиллах гэрээ байгуулсан ч байгаль хамгаалах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулаагүй, гэрээний биелэлтийг тооцоогүй байна.

Гарч байгаа зөрчлүүдээс голлох зөрчлүүдийг дурьдвал:

Хөвсгөл нуурт гадаадын иргэд /ОХУ-ын иргэд²/ зөвшөөрөлгүй загас барих зөрчил их гарсан байна. Монгол улсын Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулах амьтны олзворын жишиг үнэ, төлбөр, хураамжийн хэмжээ”-нд агнуурын загас барихад 15 ам.долларын төлбөр, хураамж төлөхөөр заасан байна. ОХУ-ын иргэд /жуулчин/ уг төлбөрийг “**Өндөр байна**” гэсэн шалтгаанаар зөвшөөрөлгүй загасчилж байна.

Мөн Ханх суманд байрлах “Мөнгөн эрэг”, “Ертөнцийн хязгаар” зэрэг жуулчны баазууд жил бүрийн 3 дугаар сард Хөвсгөл нуур дээр спорт загасчлалын тэмцээнийг ОХУ-ын иргэдийн дунд зохион байгуулж олон тооны загасыг хууль бусаар бариулж байна. Энэ нь дээрх Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоол болон Амьтны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Монгол Улсад түр буюу байнга оршин суугаа гадаадын иргэн Монгол Улсын иргэний адил хэмжээний төлбөр төлж, ахуйн зориулалтаар зөвхөн загас барьж болно” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Зураг 1: Спорт загасчлалын тэмцээн /Ханх сум/



Уг зөрчлийг арилгуулахаар Ханх сумын удирдлага, БОХУ байцаагч, байгаль хамгаалагч зэрэг холбогдох албан тушаалтнууд³ шаардлага тавин арга хэмжээ авсан ч Ханх суманд байрлах жуулчны баазуудын эзэн болон ОХУ-ын иргэд үл ойшоон, ёс бус авирлах зэргээр шаардлагыг хүлээн авдаггүй байна.

² ОХУ-ын иргэд загасны хэрэгсэл, завьтай орж ирэн зөвшөөрөлгүй загасчилдаг.

³ Зөрчлийг тухай бүр нь таслан зогсооход албан хаагчдад шаардлагатай тоног төхөөрөмж хангалтгүй байна. Тухайлбал: Завь байхгүйгээс Хөвсгөл нуурт завиар загасчилж байгаа иргэдэд шаардлага тавих боломжгүй гэх мэт

Хөвсгөлийн УТХГХЗ уг зөрчилд тодорхой арга хэмжээ авахгүй, харин зарим жуулчны баазтай “Спорт загасчлалын тэмцээнийг жил бүр зохион байгуулах, тэмцээний үеэр ахуйн зориулалтаар загас барих зөвшөөрөл нэг удаа олгоход дэмжлэг үзүүлэх” байдлаар гэрээ байгуулсан байна. Энэ нь дээрх хууль, тогтоолыг зөрчиж байна.

Хууль бусаар загасчилж буй талаар Эрхүү хот дахь консулын газраас 2013 онд Гадаад хэргийн яамны консулын газарт бичиг хүргүүлсэн ч уг зөрчил арилаагүй байна.

Аймгийн БОАЖГ-аас “Дэлгэрмөрөн, Шишхэд, Тэнгис, Эг, Үүрийн голуудад БОНХАЖЯ-аас спорт загасчлалын чиглэлээр гадаадын иргэдэд олгож буй тусгай зөвшөөрлийн бичгийг хүн нэг бүрийн нэр дээр биш загасчдын бүлгийн дунд олгож байгаагаас орон нутгийн байгаль хамгаалагч, улсын байцаагч нар хяналт шалгалт хийхэд хүндрэл учирч байна. Мөн БОНХАЖЯ 2013 оноос хойш тусгай зөвшөөрөл авсан гадаадын иргэдийг хүлээн авдаг компанийн судалгааг гаргадаг боловч аймагт уг мэдээллийг өгөхгүй байгаагаас зарим компани “Цөөн загасчид ирсэн учраас аймаг сумтай байгуулсан гэрээнд заасан хэмжээгээр загас бариулж чадаагүй” гэдэг байдлаар төлбөр, хураамжаа бүрэн төлөхгүй байх зэргээр орон нутгийн зүгээс хяналт тавихад хүндрэл учруулж байна” гэсэн санал хүсэлт ирүүлсэн бөгөөд нотлох баримтыг БОАЖГ-аас шаардахад:

2011 онд 4-5 гадаадын иргэнд 1 тусгай зөвшөөрөл өгч байсан байна. Сүүлийн жилүүдэд “Ийм байдлаар олгож байгаа” гэсэн ам тайлбарыг БОАЖГ өгсөн болно. БОНХАЖЯ компанийн судалгааг 2013 оноос аймагт ирүүлээгүй байна.

Ханх суман дахь Хилийн мэргэжлийн хяналтын хэлтсээс ирүүлсэн судалгаагаар хилийн боомтоор загас гаргах гэсэн зөрчил гарсаар байна.

Хүснэгт 4:

Огноо	Зөрчлийн тоо	Шийдвэрлэсэн байдал
2013	25	Нийт 126 кг загасыг хураан аймгийн МХГ-т шилжүүлж улсын орлого болгосон. Нийт 252000 төгрөг
2014	3	Нийт 15 кг загасыг хураан аймгийн МХГ-т шилжүүлэн улсын орлого болгосон. Нийт 30000 төгрөг
2015	9	Нийт 13 кг загасыг хураан авч аймгийн МХГ-т шилжүүлэн устгасан.


Улаан тайгын УТХГХЗ нь Улаан-Уул, Цагааннуур суманд хууль бусаар алт, ногоон хаш олборлож байсан зөрчлийг таслан зогсоож, байнгын хяналт тавин ажиллаж байгаа ч Ханх суман дахь хилийн боомтоор ногоон хашийг нууцаар нэвтрүүлэхийг оролдсон зөрчил гарсаар байна. Хилийн боомт дээр ажиллаж буй Гаалийн хороонд 2014 онд улсын төсвийн хөрөнгөөр рентгин тоног төхөөрөмж нийлүүлсэн ч уг төхөөрөмжийг ОХУ-аас орж ирж буй хэсэгт байрлуулсан тул ОХУ-руу гарч байгаа хэсэгт уг төхөөрөмж зайлшгүй шаардлагатай байгаа нь харагдлаа.

Хил орчмын сумдад үйл ажиллагаа явуулж буй зарим байгууллагуудын хамтын ажиллагаанд дараах зөрчлүүд илэрлээ.

- Ханх суманд: Хилээр нэвтэрч буй гадаадын иргэдээс Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу хураамж авч байгаа бөгөөд уг хураамжийн 10%-г хилийн заставт өгч байхаар сумын ИТХ-ын тогтоол гарсан байна. Үүний

дагуу сумын ЗДТГ хилийн заставтай гэрээ байгуулан хураамжийн орлогын 10%-г авч байна. Энэ нь хууль, эрх зүйд нийцэхгүй тул уг зөрчлийг арилгах албан шаардлага өгч ажиллалаа.

- Ханх суманд: Хилээр нэвтэрч буй гадаадын иргэдээс Хууль зүй, дотоод хэргийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2012 оны А/23/24-р хамтарсан тушаалаар “Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа авто тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам” батласны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хил хамгаалах ерөнхий газар Лоялти солишн ХХК-тай гэрээ байгуулан хилийн боомтын хяналтын талбайн бүсийн гадна хилээр нэвтэрч буй гадаадын иргэдийг даатгалд хамруулах үйл ажиллагаа явагдсан байна. Үүнийг хууль, эрх зүйд нийцэж байгаа эсэхийг тодруулахаар шийдвэрлэлээ.
- Цагаан-Үүр суманд: Сумын ИТХ-ын 2015 оны 08-р тогтоолоор Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийн хэмжээг тогтоосон байна. Гэсэн хэдий ч уг тогтоолын хуулийн үндэслэлийг буруу авсан байна. Иймд уг тогтоолыг хууль, эрх зүйд нийцүүлэн гаргахыг зөвлөж ажиллалаа.



2.1 Хил орчмын байгаль орчныг хамгаалахад тусгайлан хөрөнгө батлаагүй байна.

Хил орчмын байгаль орчныг хамгаалахад зориулан улс, орон нутгийн төсвөөс тусгайлан хөрөнгө төлөвлөөгүй ба орон нутгийн төсвөөс жил бүр байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хөрөнгийг төлөвлөж байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх дараах төсөл, арга хэмжээнд хилийн сумдууд хамрагдсан байна. Эдгээрийг сүүлийн 3 жилийн аймгийн ИТХ-аар баталсан төсөвт тусгагдсан байдлаар /ерөнхий/ харуулбал:

Хүснэгт 5:

№	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	Байршил
1	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх	Бүх сумдад
2	Эргүүл хийх, харуул гаргах, харуулын цамхаг барих	Бүх сумдад
3	Түймрийн багаж авахад	Бүх сумдад
4	Тарвага, бор гөрөөс, гахай бүхий сумдад агнуур зохион байгуулалт хийх	
5	Усны хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх	Бүх сумдад
6	Эмчилгээний зориулалтаар ашиглагдаж байгаа рашааны чанар найрлагыг тогтоох	Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур сумдад

Эдгээр төсөл, арга хэмжээний хүрээнд хилийн сумдад байгаль орчин хамгаалах чиглэлээр ажлууд хийгдэж байгаа бөгөөд байгаль орчныг хамгаалах чиглэлээрх сургалт, ухуулга сурталчилгаанд хөрөнгө түлхүү төлөвлөж байна.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн⁴ 39.1.1-д “Өөрийн нутаг дэвсгэрт байгаа Улсын хил хамгаалах байгууллагын хангалт үйлчилгээнд туслалцаа үзүүлэх ...” гэж заасны дагуу Цагаан-Уул, Баянзүрх, Ханх сумдууд хилийн заставын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэлбэрээр хөрөнгө төлөвлөж байна. Бусад хилийн сумдууд хөрөнгө төлөвлөөгүй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2013-2014 онд хилийн сумдад үйл ажиллагаа явуулж буй зарим байгууллагуудад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжилтыг баталсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6: /сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээ	Байгууллага	Огноо	Төсөвт өртөг
1	Зорчигчийн ачаа тээш шалгах рентген төхөөрөмж	Ханх суман дахь Гаалийн хороо	2013	110.0
2	Контторын барилга	Улаантайгын улсын тусгай хамгаалалттай газар	2014	425.0
3	Ажилчдын 8 айлын орон сууц	Ханх суман дахь Гаалийн хороо	2014	582.7
Дүн				1117.7

ОБЕГ⁵-аас албан хаагчдын бэлтгэл, бэлэн байдлыг сайжруулах зорилгоор ой, хээрийн түймэр унтраах зориулалтын техник, багаж зэвсэглэмжээр жил бүр хангаж ирсэн байна. Тухайлбал:

Хүснэгт 7:

Огноо	Үүргийн гал унтраагуур РЛО	Үлээгч аппарат	Галаас хамгаалах нөмрөг
2013	15	6	30
2014	30	30	
2015	25	15	

Ой хээрийн түймэртэй тэмцэх багаж, зэвсэглэмжийн нөөц бүрдүүлж байгаач холбооны хэрэгсэлээр төдийлөн хангаагүй байна. Холбооны хэрэгсэл нь богино хугацаанд холбоо тогтоон цагийн байдлыг тодорхойлох, шуурхай арга хэмжээ авах зэрэгт нэн шаардлагатай байна.

2.2 Зарим хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй байна.

Хилийн сумдын ЗДТГ-ууд улс, болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ой, хээрийн түймэртэй тэмцэх багаж, зэвсэглэмжийн нөөцтэй болсон нь түймэртэй тэмцэхэд үр нөлөөтэй болсон байна.

⁴ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргын бүрэн эрх

⁵ ОБЕГ-т 2013, 2014 онд гал түймэр болон аврах ажиллагааны тоног төхөөрөмж авах зориулалттай төсөв батлагдсан байна.

Зураг 2: Ой, хээрийн түймэртэй тэмцэх багаж, зэвсэглэмж



Ой, хээрийн түймэртэй тэмцэх багаж, зэвсэглэмжээр сумдууд хангагдсан ч зарим сумдын хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна. Тухайлбал:

- Үүргийн гал унтраагуур РЛО нь хүйтний нөхцөлд хөлдөх, уригдах зэргээс ашиглалт муу болдог бөгөөд Эрдэнэбулган суманд энэхүү багажийг шуудайнд хийн агуулахад тавьсан байв.

Зураг 3: Багаж, зэвсэглэмжийн хадгалалт



- Ханх суманд багаж, зэвсэглэмжээ тусгай галын булан хийж байрлуулалгүй харуулын ширээнд хийсэн байв.

Зураг 4: Багаж, зэвсэглэмжийн хадгалалт



Хилийн заставуудын тухайд 2013 оноос хойш шинээр ой, хээрийн түймэртэй тэмцэх техник, багаж зэвсэглэмжээр хангагдаагүй байна. Хуучин хэрэглэж байсан багаж зэвсэглэмжээ ашиглаж байна.

Зураг 5: Заставын багаж, зэвсэглэмж



Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дараах тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна.

- Ханх дахь Гаалийн хороонд улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд рентгэн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. Уг тоног төхөөрөмж нь Гаалийн хорооны байрны халаалтын асуудал хангалтгүйгээс хүйтний нөхцөлд ажиллах боломжгүй байна.

Зураг 6: Рентгэн төхөөрөмж



- 2012 онд Улсын тусгай хамгаалалттай газрын захиргааны Ханх суман дахь байцаагчид 14.75 сая төгрөгийн өртөгтэй моторт завь өгсөн ч уг завь нь нууранд явах боломжгүй тул ашиглалтгүй байна.

Зураг 7: Моторт завь



2.3 Байгаль орчинд учирсан хохирлын экологи, эдийн засгийн үндэслэлийг бодитой тооцохгүй байна.



Цагааннуур сумын 2-р багийн нутаг Жамс голын эхэнд аянганаас үүдэлтэй ой, хээрийн түймэр гарсан бөгөөд нийт 512 га ой шатсан байна. Аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн мэдээнд: “Түймрийг унтраахад 3406924 төгрөгийн зардал гарч, байгаль экологид 23500800 төгрөгийн хохирол учирсан бөгөөд хохирлыг Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Ой,

хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох” журмын дагуу тооцсон” гэсэн байна. Хохирлыг журмын дагуу бодитой тооцсон эсэхийг шалгахад:

Түймрийн хохирлыг тооцсон материалыг аудитын хугацаанд ирүүлээгүй бөгөөд хохирлыг талбайн хэмжээнд үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 394 дүгээр тушаалаар баталсан Ойн сангийн экологи эдийн засгийн үнэлгээнд суурилан тооцоолоход дээрх экологийн хохирол нь харьцангуй бага байна.

Тооцоолол:

- Ойн сангийн ойгоор бүрхэгдээгүй нэг га талбайн экологи эдийн засгийн үнэлгээг ойн нөөцийн 4 дүгээр мужаар тооцсон. 2070.0 мянган төгрөг
- Ойн шаталтын зэрэглэлийг “Сул” гэж үзэн 1 га тутмын хохирлыг ойн экологи эдийн засгийн үнэлгээний 5 хувиар тооцов.
- Хохирол: $2070.0 \times 5\% \times 512 \text{ га} = 52992.0$ мянган төгрөг

Жич: Тооцооллыг хамгийн бага үнэлгээ, эрсдэлд суурилан гаргасан болно.

Мөн аймгийн Их-Уул суманд гарсан түймрийн экологийн хохирлын тооцоог харахад: Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам”-ын 4.5-д “Түймэрт нэрвэгдсэн талбай дахь модны төрөл бүрээр тооцсон хохирлын нийлбэрээр нийт учирсан хохирлыг тогтооно” гэж заасны дагуу бус шатсан ой, хээрийн талбайн хохирлыг тооцоод, талбай дээрх модны хохирлыг тооцоогүй байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг зохицуулах зөвлөл” байгуулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажиллаж байгаа ч холбогдох байгууллагуудын түймрийн мэдээлэл зөрүүтэй, ой, хээрийн түймрийн улмаас учирсан экологийн хохирлыг бодитой тооцоогүй байна.
2. Хил орчмын гол, мөрний эхийг улсын тусгай хамгаалалтад хамруулсан байна.
3. Хөвсгөл нууранд “Спорт загасчлалын тэмцээн” нэрийн доор болон загасны тусгай зөвшөөрөл /төлбөр, хураамж/ “Өндөр үнэтэй” гэдэг байдлаар ОХУ-ын иргэд хууль бусаар олон тооны загас барьж байна.
4. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудад зөрчилтэй тэмцэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж хангалтгүй байна.
5. Хил орчмын байгаль орчныг хамгаалах чиглэлээр тусгайлан төсөв батлагдаагүй боловч шаардлагатай зүйлүүдэд хөрөнгө зарцуулагдаж хилийн сумдад тодорхой ажлууд хийгдсэн байна.
6. Ой, хээрийн түймэртэй тэмцэхэд сумдын ЗДТГ багаж, зэвсэглэмжийн нөөцтэй болсон ч зарим сумдын багаж, зэвсэглэмжийн хадгалалт хамгаалалт хангалтгүй байна.
7. Ажлын байрны нөхцөлөөс хамааран Ханх суман дахь Гаалийн хорооны рентгэн төхөөрөмж улирлын чанартай ажиллаж байна.



Аудитын дүнд үндэслэн дор дурдсан байгууллагад дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга А.Эрдэнэбаатарт

- Хил орчмын байгаль орчныг хамгаалах чиглэлээр тусгайлан хөрөнгө төлөвлөж аймгийн ИТХ-аар батлуулахад анхаарч ажиллах, холбогдох газруудад санал хүргүүлж шийдвэрлүүлэх. /Холбооны хэрэгсэл, усан тээврийн хэрэгсэл, хилийн боомтонд шаардлагатай тоног төхөөрөмж гэх мэт/
- Хууль бусаар загас барьж буй асуудлыг таслан зогсоож, орон нутагт хяналт тавихад шаардлагатай мэдээллийг БОНХАЖЯ-аас авч хамтран ажиллах.

Аймгийн БОАЖГ-ын дарга Р.Жаргалсайханд

- Хууль бусаар загас барьж буй асуудлыг таслан зогсооход тодорхой арга хэмжээ авч, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.
- Байгаль хамгаалагч нарыг зөрчилтэй тэмцэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангахад анхаарч ажиллах. /Бие хамгаалах хэрэгсэл, унаа гэх мэт/
- Түймрийн талаарх мэдээллийг бодитой гаргаж, аймгийн ОБГ, Хилийн цэргийн 0257 дугаар ангитай мэдээлэл солилцон хамтран ажиллах.
- Түймрийн улмаас учирсан экологийн хохирлыг журам, зааврын дагуу Ойн ангиудаар бодитой тооцуулах, хяналт тавьж ажиллах.

Аймгийн ОБГ-ын дарга Г.Нэргүйд

- Түймрийн талаарх мэдээллийг бодитой гаргаж, аймгийн БОАЖГ, Хилийн цэргийн 0257 дугаар ангитай мэдээлэл солилцон хамтран ажиллах.
- Түймрийн улмаас учирсан экологийн хохирлыг журам, зааврын дагуу бодитой тооцож буйд хяналт тавьж ажиллах.

Хилийн цэргийн 0257-р ангийн захирагч Б.Батбаярт

- Түймрийн талаарх мэдээллийг бодитой гаргаж, аймгийн БОАЖГ, ОБГ-тай мэдээлэл солилцон хамтран ажиллах.
- Хилийн заставуудыг ой, хээрийн түймэртэй тэмцэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж, зэвсэглэмжийн нөөцтэй болгоход анхаарч ажиллах.

Хилийн сумдын Засаг дарга нарт

- Хилийн заставуудын үйл ажиллагааг дэмжиж, шаардлагатай хөрөнгийг сумын ИТХ-аар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

Хөвсгөлийн УТХГХЗ-ны дарга Л.Даваабаярт

- Жуулчны баазуудтай хууль бус үйл ажиллагааг дэмжсэн гэрээ байгуулахгүй байх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Холбогдох байгууллагуудтай хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг нь авч тайланд тусгасан болно. /Хэлэлцүүлэгийн үед саналыг бичгээр авсан./

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

			/сая төгрөг/
№	Холбогдох байгууллага, албан тушаалтан	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн
1	Хөвсгөлийн УТХГХЗ-ны дарга Л.Даваабаяр	Жуулчны баазтай Хөвсгөл нуур дээр спорт загасчлалын тэмцээнийг зохион байгуулж, ахуйн зориулалтаар загас барих зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлэхээр гэрээ байгуулсан.	
2	ОХУ-ын иргэд /жуулчид/	Тусгай зөвшөөрөлгүйгээр загас агнасан, барьсан.	
3	БОНХАЖЯ	Аялал, жуулчлалын компаниудын загасчлалын чиглэлээр хэдэн жуулчин аялуулж байгаа талаарх судалгааг аймагт өгөхгүй болсон.	
4	Ханх сум ЗДТГ, хилийн застав	Хууль, эрх зүйн үндэслэлгүй гэрээ байгуулан УТХ-ийн орлогын /гадаадын иргэдээс авч буй/ 10 хувийг хилийн заставт олгосон.	
5	Цагаан-Үүр сумын ЗДТГ	Хууль, эрх зүйн үндэслэлгүй журам гарган иргэд болон тээврийн хэрэгслээс хураамж авсан.	
6	Ойн ангиуд	Ой, хээрийн түймрээс учирсан экологийн хохирлыг бодитой тооцоогүй.	
	Нийт дүн		